



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар A/91

Алтай хот

**Өрхөд зориулсан эрчим хүчний
хэмнэлттэй халаалт, дулаалгын төслийг
хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Агаарын бохирдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого", 98 дугаар тогтоолоор баталсан "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр", 274 дүгээр тогтоолоор баталсан "Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр", аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй "Цэвэр агаар" төлөвлөгөөний хүрээнд эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжин, агаарын бохирдол, хог хаягдлыг бууруулж, өрхөд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй халаалт, дулаалгын СИР төслийг аймагт үргэлжлүүлэн хэрэгжүүлсүгэй.

2.Төслийн Удирдлагын багийг нэгдүгээр хавсралтаар, Хэрэгжүүлэгч багийг хоёрдугаар хавсралтаар, Чанарын хяналтын багийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3.Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж, салбар дундын зохицуулалтыг хийж ажиллахыг Удирдлагын баг (Ц.Эрдэнэбат)-т, төслийг гэр хорооллын өрхөд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ажлын хэсгийг удирдлагаар хангаж, иргэдэд зөвлөн тусалж ажиллахыг Хэрэгжүүлэгч баг (Г.Хурцгэрэл)-т, багцын үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээ, чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, зөвлөн тусалж ажиллахыг Чанарын хяналтын баг (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан "Өрхөд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй халаалт, дулаалгын төслийг хэрэгжүүлэх тухай" аймгийн Засаг даргын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/437 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 20-ны
дугаар сарын 21-ны өдрийн 11-дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



УДИРДЛАГЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН Д.Ц.А.0042

Багийн дарга:

-(Аймгийн Засаг даргын орлогч)

Багийн гишүүд:

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

-(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

-(“Алтай-Улиастайн эрчим хүчний систем”

ТӨХК-ийн захирал)


-(Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн дарга)

-(Сумдын Засаг дарга нар)

Багийн нарийн бичгийн дарга: -(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

__оОо__

Аймгийн Засаг даргын 20⁰⁴ оны
04 дугаар сарын 11-ны өдрийн 11 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн дарга:

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Багийн гишүүд:

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн геологи, уул уурхай, байгаль орчин, аялал жуулчлалын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

-(“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн ерөнхий инженер)

-(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын агаарын бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн)

-(Алтай хотын Захирагчийн албаны дарга)

-(Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн Орчны технологийн хэлтсийн дарга)

-(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн)


-(“Пипл Ин Нийд” ОУТББ-ын орон нутгийн ажилтан)

-(Сумдын ажлын хэсгийн ахлагч)

Багийн нарийн бичгийн дарга:

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дугаар сарын 21-ны өдрийн 04 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



ЧАНАРЫН ХЯНАЛТЫН БАГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Багийн дарга:

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Багийн гишүүд:

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, жижиг дунд
үйлдвэрийн бодлого төлөвлөлт хариуцсан
мэргэжилтэн)

-(Есөнбулаг сумын Нийгмийн бодлого хариуцсан
Засаг даргын орлогч)

-(“Алтай-Улиастайн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн эрчим хүчний хэмнэлтийн менежер)

-(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний улсын
байцаагч)

-(Онцгой байдлын газрын галын хяналтын
байцаагч)

Багийн нарийн бичгийн дарга-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-

шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан

мэргэжилтэн)

__оОо__